



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.06.05 № 123 УАГ-САН/2013/СТА-ЗСНТ

**Авлага баталгаажуулах тухай**

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Сангийн яамны Төрийн сангийн газар нь IFAD-ийн төслийн нэгжээс 91,866,030.95 төгрөгийн, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 82,276,590.35 төгрөгийн Стандартчилал, хэмжил зүйн газраас 1,846,669.38 төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй бөгөөд дээрх байгууллагуудын санхүүгийн тайланд өглөгөөр тусгагдаагүй зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д: “санхүү, төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д: “санхүүгийн тайлан нь үнэн зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т: “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “.....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг тус тус үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна.

1. Дээрх байгууллагуудтай холбогдсон 175,989,290.68 төгрөгийн авлагыг 2013 оны 10 дугаар сарын 1-ний дотор тооцоо нийлж актаар баталгаажуулж, барагдуулах арга хэмжээг авч ажиллах
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Ариунсанаа нарт даалгаж байна

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
АУДИТОР



И.ТУЯА

УХА0122